

**ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2019 оны 03 сарын 18

**[ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР]
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭХ**

Төслийн дугаар: **ТШ-2019/БАРАА-03**

Харьцуулалт/
гэрээний дугаар:

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ]** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн жишиг бичиг баримт болон холбогдох бусад материалыг эргэн төлөгдөхгүй нөхцөлтөйгөөр иж бүрдэл /эсвэл нэмэлт хувь/-ийг 50,000 төгрөгөөр авч болно.

Үнийн саналыг **[2019 оны 03 сарын 25-ны өдрийн 14.00]**-аас өмнө **[<https://www.tender.gov.mn/>]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2019 оны 03 сарын 25]**-ны өдрийн **[14 цаг 30 минут]** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. ***Үгүй!***

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. **www.tender.gov.mn**

***Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын орлогч З.Онолбаатар, утас-89990808,
санхүүгийн албаны дарга С.Цэрэнханд утас-88434025***

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны |

мэдэгдэл

дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|--------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ТӨӨЗ 1.1 | <p>Сүүлийн [2016,2017] жилийн санхүүгийн тайлан Сүүлийн [2 жилийн] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> 1) Үнийн санал: Маягтаар ирүүлэх 2) Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар: 3) Нийгмийн даатгалын тодорхойлолт 4) Харилцагч банкуудын тодорхойлолт 5) Татварын байгууллагын тодорхойлолт: 6) Зориулалтын хүнсний агуулахтай байх /фото зургийг ирүүлэх/ 7) Ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний дэвтрийн хуулбарыг баримт бичигт хавсаргах <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [Худалдаа]</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2019 оны 03 сарын 25-ны өдрийн 14.00]-аас өмнө [https:// www.tender.gov.mn/] хаягаар ирүүлнэ. Байгууллагын хаяг: [Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын тамгын газар, Засаг даргын орлогч З.Онолбаатар, утас-89990808, санхүүгийн албаны дарга С.Цэрэнханд утас-88434025]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [1 давхар]</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: 2019 оны 03 сарын 25-ны өдрийн 14 цаг 30 минут</p> <p>Байгууллагын хаяг: [Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын тамгын газар]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [Санхүүгийн өрөө]</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1 багц</p> |

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/32 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Чандмань сумын 6 багийн 42 өрхөд нийлүүлэх, 1 сард 2,5 сая төгрөг, 12 сард 30.0 сая төгрөгийн зөвшөөрөгдсөн хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх.

2. Стандарт:

Хүнсний эрхийн бичиг авах эрх үүссэн өрхийн гишүүн-иргэдэд нийлүүлэх 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хадгалалт хамгаалалтын стандартын горимын дагуу нөөцөлсөн, бараа эргэлтийн боломж, санхүүгийн чадавхитай, сонгогдсон өрхийн гишүүн иргэдэд үйлчлэх орчин нөхцөл бүрдсэн, байршил сайтай байх. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдтэй харилцааны өндөр соёл, ёс зүйтэй харилцах, баталгаат жингээр үйлчлэх, хугацаа нь дууссан, муудаж ялзарсан, үнэр орсон бүтээгдэхүүн борлуулахгүй байх, зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнээс өөр бүтээгдэхүүн худалдахгүй байх. Бүтээгдэхүүний үнийг нийтэд харагдахаар ил тавих, хүнсний талоноор архи, согтууруулах ундаа, тамхи, ахуйн бараа худалдахыг хориглох зэрэг шаардлагыг биелүүлэх шаардлагатай.

3. Барааны жагсаалт:

| № | Нэр төрлийн дугаар | Материалын нэр | Хэмжих нэгж | Техникийн тодорхойлолт |
|---|------------------------|------------------|-------------|----------------------------------------------------------------------------------------------------------|
| 2 | СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН | Шимийн сүү | л | Гарал үүслийн бичигтэй, өнгө үнэр амт чанараа алдаагүй эсээгүй, хадгалалтын стандарт шаардлагыг хангасан |
| 3 | | Цэвэр сүү\1л\ | ш | Өнгө үнэр амт чанараа алдаагүй эсээгүй, тээвэрлэлт, хадгалалтын стандарт шаардлагыг хангасан |
| 4 | | Өглөө сүү \1л\ | ш | |
| 5 | | Аарц | кг | Шахаж бөөрөнхийлсөн шинэлэг амт чанар сайтай, тээвэрлэлт, хадгалалтын стандарт шаардлагыг хангасан |
| 6 | | ааруул | кг | Гарал үүслийн бичигтэй, хөгцгүй байна |
| 7 | | Гоё тараг\ 05 \ | ш | Өнгө үнэр амт чанараа алдаагүй эсээгүй, тээвэрлэлт, хадгалалтын стандарт шаардлагыг хангасан |
| 8 | | Гоё тараг\ 1,5 \ | ш | |
| 8 | | ЦӨ ЦГ ИЙ Н ТО С | Өрмөн тос | кг |

| | | | | |
|-----|----------------------------|---------------------------|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 9 | | Орос масло \ 50\82\ | кг | тээвэрлэлт, хадгалалтын стандарт шаардлагыг хангасан |
| 10 | | УБ Майноз \500\ | ш | |
| 11 | | УБ Майноз \1кг\ | кг | |
| 12 | Элсэн сахар | Элсэн сахар | кг | Үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа тодорхой сав баглаа боодол гэмтэлгүй хадгалалтын горим алдагдаагүй байна |
| 13 | | Ёотон сахар \1кг\ | кг | |
| 14 | | Ёотон сахар \05кг\ | кг | |
| 15 | Төмс, хүнсний ногоо | Төмс | кг | Эх орны хөрсөнд тариалсан, ялзарч муудаагүй, хөгцгүй, үрчийж сулраагүй ялгаж ангилсан шинэ ногоо байн |
| 16 | | Лууван | кг | |
| 17 | | Манжин | кг | |
| 18 | | Байцаа | кг | |
| 19 | | Сонгино | кг | |
| 20 | гурал, гурлин бүтээгдэхүүн | Гурил \ монгол \ | кг | Хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдаагүй чанартай сав баглаа боодол бүрэн бүтэн байна. Цавуулаг сайтай элдэв хольцгүй гашуун амтгүй чийглэг байдлаа алдаагүй. |
| 21 | | Ховд савхан гоймон | ш | |
| 22 | | Талх Ховд \ том \ | ш | |
| 23 | | Талх орон нутаг | ш | |
| 24 | | Алтан тариан гоймон \0.3\ | ш | |
| 25 | Будаа | Цагаан будаа | кг | Үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа тодорхой сав баглаа боодол гэмтэлгүй гарал үүсэл тодорхой хаяг шошгоны зөрчилгүй, хадгалат, тээвэрлэлтийн стандарт шаардлагыг хангасан |
| 26 | | Шар будаа | кг | |
| 27 | | Гурвалжин будаа | кг | |
| 28 | | Шар будаа \орос\ задгай | кг | |
| 29 | | Хөц будаа | кг | |
| 30 | Ургамл ын тос | Санни голд \1л\ | ш | Үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа тодорхой сав баглаа боодол гэмтэлгүй хадгалалтын горим алдагдаагүй байна |
| 31 | | Янта \1л\ | ш | |
| 32 | | Кларина \1л\ | ш | |
| 33 | өндөг | Өндөг \орос \ | ш | Үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа тодорхой сав баглаа боодол гэмтэлгүй хадгалалтын горим алдагдаагүй байна |
| 34 | | Өндөг \монгол\ | ш | |
| 35 | жимс, жимсгэнэ | Алим \орос\ | кг | Гарал үүсэл тодорхой хадгалалтын горим алдаагүй шүүслэг амт чанар сайтай |
| 36 | | Алим \хятад\ | | |
| 37 | | Чацаргана | кг | |
| 38 | | Сайн чанарын үзэм | кг | |
| 39 | | Био шүүс \Увс хүнс\ | ш | |
| 40 | мах | хонь | кг | Мал эмнэлэг ариун цэврийн, гарал үүслийн гэрчилгээтэй гадны бохирдолгүй хадгалалтын горим алдагдаагүй, шинэ мах байна |
| 41 | | ямаа | кг | |
| 42 | | үхэр | кг | |
| дүн | | | | |

4. **Баглаа, боодол:** [Хүнсний бүтээгдэхүүн нь жин хэмжээндээ бүрэн хүрсэн, баглаа боодол нь тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтээгүй байх, чанарын баталгаатай, баглаа боодол дээр тухайн бүтээгдэхүүний мэдээлэл бүрэн харагдаж байх, тухайн бүтээгдэхүүнээс шалтгаалж, гомдол санал гарсан тохиолдолд бэлтгэн нийлүүлэгч тал бүрэн хариуцна.]

Бараа хүргэх газар: [Ховд аймгийн Чандмань сумын Урдгол багийн төв

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газар)-ын дарга
_____ танаа

1. Бид, [.....] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнэ** **тоогоор** **үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [.....] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---------------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|----------------------------------------------|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]